БАТЛАВ:
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.ИДЭРБАТ

Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат, 15 айлын орон сууц барих / Баруун-Урт сум /

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг хийлгэсэн байна.

Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд төрийн албан хаагчдад зориулсан 15 айлын орон сууцны барилга барих ажлыг хийж гүйцэтгэнэ. Дээрхи ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөл (Зураг төслийн шифр: ХТХ-06/2025) дагуу хийж гүйцэтгэх ба стандарт, технологийн дагуу хийж гүйцэтгэж ашиглалтад оруулна.

Орон сууцны барилгын ажилд:

Барилгын угсралтын ажил гүйцэтгэх явцад барьцалдуулах зуурмаг, шавардлага зэрэгт туршилт, сорилт, хяналт шалгалтыг талбай дээр ажлыг хийж гүйцэтгэж байх хугацаанд байвал зохино. Барилгад бүх материал нь улсын стандартад нийцсэн материал сонгосон байх шаардалагатай.

Баруун-Урт сумын орон сууцны суурьшлын бүсэд зоорьгүй 2 давхар орон сууцны барилга төлөвлөсөн ба эдэлбэр газар 1648м2, үүнээс барилгажих талбай 545м2, явган зам талбай, тоглоомын зам талбай 530м2, ногоон байгууламж 572м2 эзэлнэ.

-Үүнээс үндсэн барилгын гадна шугам сүлжээ, гадна тохижилтын ажлыг батлагдсан төсвийн дагуу нэмэлт ажлын гэрээ байгуулан захиалагч байгууллагатай зөвшилцөж хийж гүйцэтгэх.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын засварын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Магадлашгүй ажлыг хэрхэн, ямар ажилд зарцуулах талаар Захиалагчийг төлөөлж техник хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага болон хяналтын инженерт танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс гаргана. Зөвшөлцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлын зардлыг санхүүжүүлэхгүй болно.

Тус ажлын зураг төсвийн зардал болох 48,005,000 (Дөчин найман сая таван мянга)-төгрөгийг төсөвт тооцож ирүүлнэ.

Техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

З.МӨНХБАЯР